германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Хаан банк - Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Байгууллага, аж ахуйн нэгжийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах зориулалтаар олгогдоно.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авах болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй байраа шинэчлэх, засварлах, худалдан авах, өргөтгөх зэрэг зориулалтаар олгогдох зээл.

**Зээлийн шугам:** Батлагдсан зээлийн эрхийн хэмжээ болон хугацааны хүрээнд эргэлтийн хөрөнгийн хэрэгцээнээс хамаарч олгогдох эргэн төлөлтийн уян хатан нөхцөл бүхий зээл.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтай аж ахуйн нэгж байх;
- Сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх;
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх;
- Хөрөнгө оруулалтын зээлийн хувьд нийт санхүүжилтийн 30-аас багагүй хувийг өөрөө санхүүжүүлсэн санхүүжүүлэх боломжтой байх
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх;
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх;
- Бусад

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл | Зээлийн шугам |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | уян хатан тогтооно | уян хатан тогтооно | уян хатан тогтооно |
| **Хугацаа** | 36 хүртэл сар (¥: 18 хүртэл сар) | 84 хүртэл сар | 12-24 хүртэл сар |
| **Хүү /Сарын/** | ₮: 1.6%-1.9%<br>$: 1.0% - 1.5%<br>¥: 1.1%-1.5% | ₮: 1.8%-1.95%<br>$: 1.04% - 1.5% | ₮: 1.7%-1.9%<br>$: 1.0% - 1.5% |
| **Хүү /Жилийн/** | ₮: 19.2% - 22.8%<br>$: 12.0% - 18.0%<br>¥:13.2% - 18.0% | ₮: 21.6% - 23.4%<br>$: 12.5% - 18.0% | ₮: 20.4% - 22.8%<br>$: 12.0% - 18.0%<br>Коммитмент жилийн хүү: 4% |
| **Өргөдлийн хураамж** | байхгүй | байхгүй | байхгүй |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | ₮: 1% (1.5 сая төгрөг хүртэл)<br>$: 0.5% (1,500 ам.доллар хүртэл)<br>¥: 0.5% (7,500 юань хүртэл) | ₮: 1% (1.5 сая төгрөг хүртэл)<br>$: 0.5% (1,500 ам.доллар хүртэл) | ₮: 1% (1.5 сая төгрөг хүртэл)<br>$: 0.5% (1,500 ам.доллар хүртэл) |

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД

- Зээлийн маягт (Банкны салбараас эсхүл энд дарж татаж авна уу);
- ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Байгууллагын дүрэм, танилцуулга;
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;
- Зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол;
- Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхийн эх хувь, эх хувиар авчрах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, сүүлийн 6 сарын хугацааны цээж зураг;
- Барьцаанд тавих хөрөнгийн баримт бичгүүд;
- Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан болон бусад орлого, зарлагыг нотлох баримтууд;
- Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл;
- Сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд;
- Бусад.

**Хаан банкнаас олгож буй нийт зээлүүд:**

*Эргэлтийн хөрөнгийн зээл, Зээлийн шугам, Барилгын зээл, Хөрөнгө оруулалтын зээл, Техникийн хөрөнгө оруулалтын зээл, Гэрээ барьцаалсан бизнесийн зээл, Бичил, эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын болон техникийн хөрөнгө оруулалтын зэрэг 4 төрлийн газар тариалангийн зээл, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн зээл, “ЖАЙКА” жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах II үе шаттай төслийн зээл, “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх”-ийн төслийн зээл, Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгчдэд зориулсан бизнесийн зээлийн шугам болон авлага барьцаалсан зээлүүд, Ногоон эдийн засгийг дэмжих зээлүүдийг тус тус олгож байна.*

*Булган аймагт: “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн зээл болон “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих жижиг зээл”-ийг олгож байна.*

***УЛААНБААТАР:*** ***Хаан банк цамхаг, Чингисийн өргөн чөлөө-6, Стадион оргил-1, Хан-Уул дүүрэг***

***БУЛГАН:*** ***Булган сум, 6-р баг, Магсаржавын гудамж***

***ОРХОН:*** ***Орхон аймаг, Баян-Өндөр сум, Согоот баг***

***ХОВД:*** ***Жаргалант сум, Жаргалан баг***

***1800-1917***

***help@khanbank.com***
***www.khanbank.com***

# Худалдаа хөгжлийн банк – Бизнесийн зээл

### ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бизнесийн бичил зээл:** Бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч, банкны ПОС, TDB Pay мерчант иргэд, аж ахуйн нэгж байгууллагад зориулсан үл хөдлөх хөрөнгийн барьцаа шаардахгүй зээл.

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулсан зээл юм.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор техник, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, барих, өргөтгөх, засварлах зориулалттай зээл.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Бизнесийн бичил зээл:**

Сүүлийн нэг жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн байх
Сүүлийн 6-н сар тогтмол орлого хүлээн авсан Худалдаа, хөгжлийн банкны ПОС, TDB Pay мерчант байх эсвэл томоохон зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн түрээслэгч эсвэл өмчлөгч байх
Бараа материал, дансны орлого, баталгаа, хөдлөх хөрөнгө барьцаалах

**Эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээл:**

- Эрхэлж буй бизнесийн чиглэлээр 1-ээс доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, төлбөрийн чадвартай байх
- Хугацаа хэтэрсэн зээл, хүүгийн өр төлбөргүй
- Банкны шаардлага хангасан барьцаа хөрөнгөтэй байх
- Хөрөнгө оруулалтын нийт төсвийн 20-30 хувиас багагүй хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх (хөрөнгө оруулалтын зээлний хувьд)
- ХХБ-ны зүгээс тавих бусад шаардлагыг хангасан байх

### ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бизнесийн бичил зээл | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | ХХБ-ны ПОС, TDB pay мерчант: 30 сая төгрөг хүртэл Бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгч: 15 сая төгрөг хүртэл | 350.0 сая төгрөг хүртэл болон 350.0 сая төгрөгөөс дээш | 350.0 сая төгрөг хүртэл 350.0 сая төгрөгөөс дээш |
| **Хугацаа** | 36 сар хүртэл | 36 сар хүртэл | 60 сар хүртэл; 36 сар хүртэл |
| **Хүү /Сарын/** | ₮: 1.5%-1.7%; ₮: 1.6% - 1.9% | ₮: 1.6%-1.9%; Уян хатан | ₮: 1.6%-1.9%; Уян хатан |
| **Хүү /Жилийн/** | ₮: 18.0%-20.4%; ₮:19.2% - 22.8% | ₮: 19.2% -22.8%; Уян хатан | ₮: 19.2% -22.8%; Уян хатан |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | 0.5% (хамгийн багадаа 50 мянган төгрөг) | 0.3% (хамгийн багадаа 50 мянган төгрөг) | 0.3% (хамгийн багадаа 50 мянган төгрөг) |

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

| Иргэн | Аж ахуйн нэгж |
|---|---|
| • Зээлийн өргөдөл (Банкны салбараас эсвэл энд дарж татаж авна уу.)<br>• Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүнд мөн адил хамаарна)<br>• Түрээсийн гэрээ, дансны хуулга, бараа материалын үлдэгдэл<br>• Гэрлэлтийн гэрчилгээ (Гэрлээгүй бол гэрлэсэн эсэх лавлагаа)<br>• Бусад шаардлагатай баримт бичгүүд (Үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөл гэх мэт) | • Зээлийн өргөдөл (Банкны салбараас эсвэл энд дарж татаж авна уу.)<br>• Улсын бүртгэлийн гэрчилгээ<br>• Компанийн гэрээ, дүрэм<br>• Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчдийн зөвшөөрөл<br>• Санхүүгийн тайлан (сүүлийн 2-3 улирлын)<br>• Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз<br>• Барьцаа хөрөнгийн гэрчилгээ /эх хувиар/, үнэлгээний тайлан /орон сууцанд хамаарахгүй/, газар эзэмших гэрчилгээ<br>• Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд<br>• Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд<br>• Бусад шаардлагатай баримт бичгүүд |


***УЛААНБААТАР:***
***Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, ХХБ-ны төв байр***

***ОРХОН:***
***Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Эрдэнэт салбар***

***1800-1977***
***1900-1977***

***info@tdbm.mn***
***www.tdbm.mn***

# Худалдаа хөгжлийн банк – Төслийн зээл

| Төрөл | Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл | Азийн хөгжлийн банкны эх үүсвэр, Зээлийн батлан даалтын сангийн батлан даалттай төслийн зээл | Бизнесийн ногоон зээл |
|---|---|---|---|
| **Зориулалт** | Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банкны санхүүжилт, хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эмэгтэй гүйцэтгэх удирдлагатай болон эмэгтэй ажилтнууд давамгайлсан бизнес, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй санхүүжилт санал болгож Монгол Улсын тогтвортой хөгжлийг дэмжихэд хувь нэмрийг оруулах. | Жилийн борлуулалтын орлого 2.5 тэрбум төгрөгөөс дээшгүй жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих зориулалттай.<br><br>Зээл нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой бөгөөд харилцагч та зээлээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломжтой. | Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг дэмжихэд зориулагдана. |
| **Хэмжээ** | 1.0 тэрбум төгрөг хүртэл | 2 тэрбум төгрөг хүртэл | Уян хатан |
| **Хугацаа** | 36 сар хүртэл | 10 жил хүртэл | 36 сар хүртэл |
| **Хүү /Жилийн/** | Төгрөг – 15.0% | 8.88%-12.34% | 15% |
| **Тавигдах шаардлага** | Банкны үндсэн шаардлагуудаас гадна дараах шаардлагын аль нэгийг биелүүлсэн байна:<br>• Хувьцаа эзэмшигчдийн 51% ба түүнээс дээш хувьд эмэгтэй хувьцаа эзэмшигч байх<br>• Эмэгтэй гүйцэтгэх/ерөнхий захиралтай байх<br>• Нийт ажилтнуудын 50% ба түүнээс дээш эмэгтэй ажилтнууд байх | Зээл хүсэгч нь хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх<br>1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх<br>Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх<br>Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх<br>Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх | 1 жил ба түүнээс дээш хугацаагаар тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн<br>Байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөгүй<br>Ажлын байрыг нэмэгдүүлэх |
| **Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа** | 12 сар хүртэл | 24 сар хүртэл | 12 сар хүртэл |
| **Барьцаа** | Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө | Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө | Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө |
| **Бусад** | | Зээлийн дүнгийн 30%-60% /1.2 тэрбум сая төгрөг хүртэл/-д батлан даалт гаргах боломжтой. | ХХБ-ны "Тогтвортой санхүүжилтийн хамрах хүрээ"-д багтсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ. / ЭНД дарж танилцана уу / |

**ХХБ-наас олгож буй нийт зээлүүд**:

*Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл, Бизнесийн бичил зээл, Авлага барьцаалсан зээл, "Оюу-Толгой" ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгчид зориулсан бизнесийн зээл, Биет болон биет бус алт барьцаалсан зээл, Овердрафт зээл, Үл хөдлах хөрөнгийн зээл, Тоног төхөөрөмжийн зээл, Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээл, Ажлын байрыг дэмжих зээл, Хөдөлмөн эрхлэлтийг дэмжих зээл, Бизнесийн ногоон зээл, АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил" төслийн зээл, АХБ-ны эх үүсвэртэй, зээлийн батлан даалтын сангийн батлан даалттай зээл, "ЖАЙКА" жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах II үе шаттай төсөл"-ийн зээл, Репо санхүүжилтийн зээл зэрэг зээлүүдийг олгож байна.*


***УЛААНБААТАР:***
***Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19, ХХБ-ны төв байр***

***ОРХОН:***
***Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Эрдэнэт салбар***

***1800-1977***
***1900-1977***

***info@tdbm.mn***
***www.tdbm.mn***

# Хас банк – Бичил, жижиг, дунд бизнесийн зээл

### ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бичил зээл:** Бизнесийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, бизнесээ өргөжүүлэх, өрх гэрийн хэрэглээг санхүүжүүлэх зориулалттай.

**Жижиг, дунд бизнесийн зээл:** Өөрийн бизнесийн онцлогт тохирсон уян хатан нөхцөлтэй зээл авч бизнестээ хөрөнгө оруулалт хийхэд зориулан авах боломжтой.

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Шинээр бизнес эрхлэх гэж буй болон эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, бизнесээ өргөжүүлж ашиг орлогоо өсгөхөөр зорьж байгаа бол авах боломжтой.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Сүүлийн 6 сарын хугацаанд тухайн бизнесийн үйл ажиллагаагаа явуулсан байх;
- Тухайн бизнесийн үйл ажиллагаар эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан, зөвшөөрөл нь зээл төлөгдөж дуусах хүртэл хүчин төгөлдөр байх эсхүл тодорхой хугацаагаар олгогддог тусгай зөвшөөрлийн хувьд цаашид сунгагдах боломжтой байх;
- Бусад банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд муу зээлийн түүхгүй байх;
- Бизнесийн орлого зарлагаа тогтмол хөтөлдөг ба бүртгэл /хуулийн этгээдийн хувьд нягтлан бодох бүртгэл/ хөтлөлт нь тухайн бизнесийн үйл ажиллагааны тухай бодит мэдээллийг илэрхийлэх боломжтой байх;
- Банкнаас шаардсан материалыг үнэн зөв, бүрэн гаргадаг байх;
- Бизнес хийх явцдаа хуулийн этгээд байгуулан үйл ажиллагаа явуулж байсан бол уг хуулийн этгээд нь дампуурсан эсхүл муу зээлийн түүхгүй байх;

### ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бичил бизнесийн зээл | Жижиг бизнесийн зээл | Дунд бизнесийн зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 30.0 сая төгрөг хүртэл | 30.0 – 300.0 сая төгрөг хүртэл | 300.0 сая – 1.0 тэрбум төгрөг хүртэл |
| **Хугацаа** | Эргэлтийн хөрөнгийн зээл: 36 хүртэл сар<br>Үндсэн хөрөнгийн зээл: 60 хүртэл сар<br>Шугамын зээл: 36 хүртэл сар (жижиг, дунд зээл) | | |
| **Хүү Сарын** | ₮: 1.5% - 1.8% | ₮: 1.5% - 1.8%<br>$: 1.1% - 1.5% | |
| **Хүү Жилийн** | ₮: 18.0% - 21.6% | ₮: 18.0% - 21.6%<br>$: 13.2% - 18.0% | |
| **Хүү буурах нөхцөл** | Банкнаас авсан зээлийн тоо болон банкинд байршуулсан эх үүсвэрийн багцаас хамаарч зээлийн хүүг бууруулна. | | |
| **Зээл олголтын шимтгэл** | 1% | Төгрөг: 1%<br>Ам.доллар: 0.5% | |
| **Зээлийн шугамын үүрэг хүлээсний шимтгэл** | | 500 сая төгрөг хүртэл: 0.2%<br>500 сая төгрөгөөс дээш: 0.25%<br>Ам.доллар: 0.1% | |

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

| Иргэн | Хуулийн этгээд |
|---|---|
| • Зээлийн өргөдөл /ХасБанкны маягтаар татаж авах/;<br>• Иргэний үнэмлэхийн хуулбар;<br>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэхтэй холбоотой зөвшөөрөл, лиценз, патент, ажлын байрны дүгнэлт, түрээсийн гэрээ;<br>• Бизнесийн орлоготой холбоотой баримтууд;<br>• Орон сууц, хашаа байшин, газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээ;<br>• Банкны зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт материал | • Бичил зээлийн өргөдөл /ХасБанкны маягтаар татаж авах/;<br>• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар батлуулсан хуулбарын хамт/;<br>• Гүйцэтгэх удирдлагын цээж зураг, иргэний үнэмлэхийн хуулбар /зөвхөн анх удаа зээл хүсэгчид хамаатай/;<br>• Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээ /нотариатаар батлуулсан хуулбарын хамт/;<br>• Өмнөх 1 жилийн болон сүүлийн улирлын Татварын албанаас баталгаажуулсан тайлан тэнцлийн хуулбар;<br>• Зээлээр санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцлийн хуулбар;<br>• Барьцаалуулах хөрөнгийг өмчлөх эрхийн гэрчилгээ;<br>• Банкны зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт материал |

**ХАС банкнаас олгож буй нийт зээлүүд:**

*Эргэлтийн хөрөнгийн зээл, Зээлийн шугам, Үндсэн хөрөнгийн зээл, Хүлэмжийн хийг бууруулах зорилгоор олгогдох бизнесийн зээл, Агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн бизнесийн ногоон зээл, "ЖАЙКА жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах II үе шаттай төсөл"-ийн зээл, "Органик Монгол" хөтөлбөрийн зээл, Европийн Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Хамтын Санхүүжилтийн гэрээний хүрээнд олгох зээл, АХБ-ЗБДС-ийн хамтарсан "Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийн төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр"-ийн зээлүүдийг олгож байна.*

***УЛААНБААТАР:*** *СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр*

***БУЛГАН:*** *Булган сум, 5-р баг, Магсаржавын гудамж, ХасБанкны байр /4-н замын баруун урд талд/*

***ОРХОН:*** *Баян-Өндөр сум, Эрдэнэт хот, "Баян" худалдааны төвийн 1 болон 5 давхарт*

***ХОВД:*** *Жаргалант сум, Жаргалан баг, ХасБанкны байр*

***1800-1888***
***7577-1888***

***info@xacbank.mn***
***www.xacbank.mn***

# Голомт банк –Бизнесийн зээл

### ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Үйлдвэрлэлийн зээл**

Эргэлтийн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын хэрэгцээний аль алийг нь шийдэх зорилготой зээл юм.

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Бизнес эрхлэгч Иргэн, Аж ахуйн нэгжийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах зориулалтаар олгогдоно.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнес эрхлэгч Иргэн, Аж ахуй нэгж байгууллагууд үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, техник технологи болон тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үйл ажиллагааны ашиг орлого, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор үндсэн хөрөнгө бэлтгэх, өргөтгөх, хөрөнгө оруулалт хийх, тоног төхөөрөмжөө шинэчлэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулагдан олгогдоно.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх
- Сүүлийн 12 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх
- Бусад

**Үйлдвэрлэлийн зээлийн хувьд:**

- Боловсруулах үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байх
- Сүүлийн 4 жилийн турш үйл ажиллагаа явуулсан ААН байх
- ААН болон хувьцаа эзэмшигчид нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн түүхгүй байх
- Банкны бусад шаардлагыг хангах

### ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Үйлдвэрлэлийн зээл | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | Банкны өөрийн хөрөнгийн 20 % хүртэл төгрөг түүнтэй тэнцэх валют | Банкны өөрийн хөрөнгийн 20% хүртэл төгрөг түүнтэй тэнцэх валют | Банкны өөрийн хөрөнгийн 20% хүртэл төгрөг түүнтэй тэнцэх валют |
| **Хугацаа** | 60 сар хүртэл | 36 сар хүртэл | 60 сар хүртэл |
| **Хүү /Сарын/** | ₮: 1.4% -1.7%; | ₮: 1.4% -1.7%; $: 0.75%-1.16%; | ₮: 1.4% -1.7%; $: 0.7% -1.3%; |
| **Хүү /Жилийн/** | ₮: 16.8% -20.4%; | ₮: 16.8% -20.4%; $: 8.4%-13.2%; | ₮: 16.8% -20.4%; $: 8.4% – 15.6% |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | 0.5% (зээлийн хугацаа 12 сар хүртэл); 1.0% (зээлийн хугацаа 12 сараас дээш) | 0.5% (зээлийн хугацаа 12 сар хүртэл); 1.0% (зээлийн хугацаа 12 сараас дээш) | 0.5% (зээлийн хугацаа 12 сар хүртэл); 1.0% (зээлийн хугацаа 12 сараас дээш) |
| **Өргөдлийн хураамж** | 10,000 төгрөг | 10,000 төгрөг | 10,000 төгрөг |
| **Зээлийн нөхцөл өөрчилсний шимтгэл** | | 0.3% – 0.5% /Зээлийн график өөрчлөх, Хугацаа сунгах, Барьцаа хөрөнгө солих/ | 0.30% – 0.50% /Зээлийн график өөрчлөх, Хугацаа сунгах, Барьцаа хөрөнгө солих/ |

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

| Иргэн | Аж ахуйн нэгж |
|---|---|
| • Цахим үнэмлэхний хуулбар /Хур систем/<br>• Зээлийн хүсэлт /Гараар бичсэн өргөдөл байх ба хүсч буй зээлийн хэмжээ, хүү, хугацаа, зээлийн зориулалт зэргийг заавал тусгасан байх/<br>• Өргөдлийн маягт /Банкны хэвлэмэл маягт/ | • Зээлийн маягт* (Банкны салбараас)<br>• ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ*, Байгууллагын дүрэм, танилцуулга<br>• Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл<br>• Зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол<br>• Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхийн эх хувь, эх хувиар авчрах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, сүүлийн 6 сарын хугацааны цээж зураг<br>• Барьцаанд тавих хөрөнгийн баримт бичгүүд*<br>• Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан болон бусад орлого, зарлагыг нотлох баримтууд*<br>• Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл*<br>• Сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд<br>• Бусад |

***УЛААНБААТАР:*** *Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22, Голомт банкны Төв байр*

***ХОВД:*** *Ховд аймаг, Жаргалант сум, Магсаржав баг, Голомт банкны байр*

***ОРХОН:*** *Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Харх ХХК-ийн байр*

***1800-1646***

***mail@golomtbank.com***
***www.golomtbank.com***

# Голомт банк –Бизнесийн бусад зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл:** Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй эсвэл эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүд бараа материал худалдан авах болон үйл ажиллагааны ашиг, орлогоо нэмэгдүүлэх зориулалтаар авах боломжтой.
**Тогтвортой, ногоон бизнесийн зээл:** Бизнесийн үйл ажиллагаандаа Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын хувьд тогтвортой байдлыг нэвтрүүлэх, Байгаль орчинд ээлтэй байхыг зорьж буй Бизнес эрхлэгч Иргэн, аж ахуй нэгжид зориулсан зээл.
**“Оюу-Толгой” ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгчид зориулсан бизнесийн зээл:** Орон нутагт бизнес эрхэлж буй бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, гэнэтийн санхүүгийн хэрэгцээг шийдвэрлэх зорилгоор олгож буй зээл.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх
- Сүүлийн 12 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх
- Банкны шалгуур болох санхүүгийн харьцаануудыг зохих түвшинд хангасан байх
- Банкны шаардлага хангахуйц барьцаа хөрөнгөтэй байх
- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэлгүй байх
- Банк болон ББСБ-аас авсан зээл нь муу ангилалд ангилагдсан түүхгүй байх
- Бусад

**Тогтвортой, ногоон бизнесийн зээлийн нэмэлт шаардлага**

- Сүүлийн 12 сараас доошгүй хугацаанд тогтвортой бизнес эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх
- Бизнесийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Монголбанкны Ногоон Таксаномид багтсан байх
- Эрсдлийн түвшингээс хамааран Байгаль Орчин, Нийгмийн Эрсдлийн Үнэлгээний дотоод журмын ногоон шаардлагыг биелүүлсэн байх

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээлийн нэмэлт шалгуур**

- Гүйцэтгэх удирдлага нь эмэгтэй хүн байх;
- Компанийн 51-ээс дээш хувийг эмэгтэйчүүд эзэмшдэг байх;
- ТУЗ-ийн гишүүд болон Удирдлагын багийн аль нэгний хамгийн багадаа 30% нь эмэгтэйчүүд эзэлдэг байх;
- Нөхөрлөл, Хоршооны гишүүдийн 51.0%-аас дээш нь эмэгтэй гишүүд байх хоршооны дарга нь эмэгтэй байх;
- Нийт ажиллагсдын хамгийн багадаа 50.0% нь эмэгтэйчүүд байх.

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл* | Тогтвортой, ногоон бизнесийн зээл | “Оюу-Толгой” ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгчид зориулсан бизнесийн зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 100.0 сая төгрөг хүртэл | 500.0 сая – 1 тэрбум төгрөг хүртэл | Нэхэмжлэлийн дүнгийн 90% |
| **Хугацаа** | 36 сар хүртэл | 30-84 сар | 24 сар хүртэл |
| **Хүү /Жилийн/** | 14.4% – 16.8% | 14.4% – 16.8% | 13.8% - Бодлогын хүү +4% |
| **Зээл олгох шимтгэл** | 0.5% | 0.5%-1.0% | |
| **Өргөдлийн хураамж** | 10,000 төгрөг | 10,000 төгрөг | 10,000 төгрөг |
| **Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа** | 12 хүртэл сар | 12-24 сар хүртэл | |
| **Барьцаа хөрөнгө** | 1-12 сар: Дансны орлого;<br>13-24 сар: Тоног төхөөрөмж, бараа материал;<br>25-36 сар: Хөдлөх болон Үл хөдлөх хөрөнгө | Банкны шаардлага хангасан барьцаа хөрөнгө байх | Авлагын дүн 100% |

*Хуулийн этгээдийн хувьд хувьцаа эзэмшигч нь Засгийн газрын тогтоол гарсанаас хойш буюу 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс хойш өөрчлөгдөөгүй байх;

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

**“Оюу-Толгой” ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгчид зориулсан зээл**

- ААН гэрчилгээ, дүрэм
- Оюу толгой ХХК-тай байгуулсан гэрээ, нэхэмжлэх
- Хувьцаа эзэмшигчдийн ИҮХуулбар, хорооны тодорхойлолт
- Компаний татварын тодорхойлолт
- Компани болон Хувьцаа эзэмшигчид дээр Шүүхийн шийдвэрийн лавлагаа

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээл**

- Зээлийн маягт (Банкны салбараас)
- ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Байгууллагын дүрэм, танилцуулга
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- Зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол
- Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхийн эх хувь, эх хувиар авчрах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, сүүлийн 6 сарын хугацааны цээж зураг
- Барьцаанд тавих хөрөнгийн баримт бичгүүд
- Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан болон бусад орлого, зарлагыг нотлох баримтууд
- Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл
- Сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд
- Бусад

*УЛААНБААТАР: Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22, Голомт банкны Төв байр*

*ХОВД: Ховд аймаг, Жаргалант сум, Магсаржав баг, Голомт банкны байр*

*ОРХОН: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Харх ХХК-ийн байр*

*1800-1646*

*mail@golomtbank.com*
*www.golomtbank.com*

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Голомт банк –Төслийн зээл

| Төрөл | ”ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжих” төслийн зээл | ”ЖАЙКА ЖДҮ-ийг хөгжүүлэх, БО-ыг хамгаалах” төслийн зээл | АХБ-ны санхүүжилттэй ЗБДС-гийн батлан даалттай төслийн зээл |
|---|---|---|---|
| **Зориулалт** | АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр агробизнесийн чиглэлийн хувийн ААН-үүдийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой. | Японы олон улсын агентлаг ЖАЙКА-ын эх үүсвэрээр ЖДҮ болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн эргэлтийн хөрөнгө, тоног төхөөрөмж болон үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламжийн өргөтгөлийн санхүүжилтийг хангах зорилготой. | Барьцаа хөрөнгийн дутагдалтай ЖДҮ эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой бөгөөд зээлээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломжтой. |
| **Хэмжээ** | 150,000 – 3,000,000 ам.доллар /тэнцэх төгрөг/ | 800,000,000 хүртэл төгрөг /тэнцэх ам.доллар/ | Зээл: 2,000,000,000 хүртэл төгрөг<br>Батлан даалт: 30%-60% |
| **Хугацаа** | 7 жил хүртэл | 10 жил хүртэл | 10 жил хүртэл |
| **Хүү /Жилийн/** | Төгрөг – 8.00%<br>Ам.доллар – 7.00% | Төгрөг – 9.81%<br>Ам.доллар – 6.0% | 8.88%-12.34% (Батлан даалтын хэмжээнээс шалтгаална.) |
| **Тавигдах шаардлага** | • ХАА гаралтай түүхий эдийн боловсруулалтыг сайжруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд нэмүү өртөг шингээх<br>• Экспортыг дэмжиж, импортыг орлох<br>• Бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх<br>• Ажлын байрыг нэмэгдүүлэх<br>• Байгаль орчин, нийгэмд ээлтэй<br>• Нийгэм, жендерийн тэгш байдлыг хангасан байх | • Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт түүний үр ашигтай нөхцөлийг хангасан ажлын байр шинээр бий болгож байх<br>• 1 жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх<br>• Зээл хүсэгч нь өмнөх улирлын тайлан балансаа гаргаж, татварын албаар баталгаажуулсан байх<br>• Байгаль орчны үнэлгээ хийлгэсэн байх<br>• Эрхзүйн хувьд бүрэн чадамжтай байх<br>• Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх | • Ажлын байрыг нэмэгдүүлэх<br>• Хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа эрхэлдэг байх<br>• Сүүлийн 6 сарын хугацаанд хугацаа хэтэрсэн, чанаргүй өр зээлийн үлдэгдэл үүсээгүй байх<br>• Зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байх, төсөл энгийн ойлгомжтой<br>• ЖДҮ эрхлэгч байх (гэрчилгээ, тодорхойлолт)<br>• Банкны бизнесийн зээлийн журмын нийтлэг шалгуурыг хангасан байх |
| **Үнд.төлбөрөөс чөлөөлөх хугацаа** | 3 жил хүртэл | - | 2 жил хүртэл |
| **Бүрдүүлэх материал** | • Зээл хүссэн өргөдөл, анкет<br>• ААН, хоршооны гэрчилгээний хуулбар, сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан<br>• Зээлийн зарцуулалт болон орлого, зарлагыг баримтжуулсан баримтууд<br>• Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд<br>• Төслийн танилцуулга<br>• Байгаль орчины нөлөөллийн үнэлгээний дүгнэлт | • Зээл хүссэн өргөдөл<br>• Төсөл /эх хувиараа/<br>• Зээл хүсэгчийн хувийн мэдээлэл /анкет, 1 хувь цээж зураг, иргэний үнэмлэхний хуулбар, хорооны тодорхойлолт гэх мэт/<br>• Зээлийн зарцуулалт болон орлого зарлагыг баримтжуулсан баримтууд<br>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх зөвшөөрөл<br>• Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд<br>• ЖДҮ тодорхойлолт<br>• Бусад /дансны хуулга, компаний гэрчилгээ, дүрэм гэх мэт/ | • Зээл хүсэгч, хамтран зээл хүсэгчийн иргэний үнэмлэхний хуулбар<br>• Бизнесийн товч танилцуулга<br>• ЖДҮ эрхлэгчийн гэрчилгээ, тодорхойлолт<br>• Зээл хүсэгч, хамтран зээл хүсэгчийн оршин суугаа газрын тодорхойлолт<br>• Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл<br>• Бүрэн бөглөсөн байгаль орчин, нийгмийн үнэлгээний 6 ажлын хуудас<br>• Бүрэн бөглөсөн батлан даалтын өргөдлийн маягт<br>• Орлого нотлох баримтууд<br>• Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан<br>• Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд<br>• ЗБДС-гийн төслийн өргөдлийн хураамж төлсөн баримт |

**Голомт банкнаас олгож буй нийт зээлүүд**:
*Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл, Тоног төхөөрөмжийн зээл, Үйлдвэрлэлийн зээл, Зээлийн шугам, Тогтвортой, ногоон бизнесийн зээл, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл, Репо санхүүжилтийн зээл, ПОС-ын орлого барьцаалсан зээл, Худалдаа үйлчилгээний талбайн зээл, Гэрээний орлого барьцаалсан зээл, “Оюу-Толгой” ХХК-ийн бэлтгэн нийлүүлэгчид зориулсан бизнесийн зээл болон АХБ “ХАА, хөдөөгийн хөгжлийг дэмжих” төслийн зээл, ЖАЙКА ”ЖДҮ-ийг хөгжүүлэх, БО-ыг хамгаалах” төслийн зээл, АХБ-ны санхүүжилттэй ЗБДС-гийн батлан даалттай төслийн зээлзэргийг олгож байна.*


***УЛААНБААТАР:*** ***Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22, Голомт банкны Төв байр***

***ХОВД:*** ***Ховд аймаг, Жаргалант сум, Магсаржав баг, Голомт банкны байр***

***ОРХОН:*** ***Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Харх ХХК-ийн байр***

***1800-1646***

***mail@golomtbank.com***
***www.golomtbank.com***

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Төрийн банк - Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл:** Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн амьжиргааны төвшинг дээшлүүлэх зорилгын хүрээнд хувиараа эрхэлж буй бизнес болон эмэгтэйчүүд байгуулсан хуулийн этгээд /компани, нөхөрлөл, хоршоо/-ийн эргэлтийн хөрөнгө, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зориулан олгоно.

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах зорилгоор хийгдэх төрөл бүрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулагдана.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх, үйл ажиллагааны ашиг орлого, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор суурь эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зорилгоор техник технологи болон тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө бэлтгэх, хөрөнгө оруулалт хийх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулагдана.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Сүүлийн 12 сар тасралтгүй тухайн бизнесийг эрхэлсэн туршлагатай /бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээлийн хувьд 6 сар/,
- Бизнесийн тогтмол мөнгөн урсгалтай, үйл ажиллагааны цэвэр мөнгөн орлогын 70%-иас хэтрэхгүй дүнгээр зээл, зээлийн хүүг хуваарийн дагуу хэсэгчлэн төлөх чадвартай,
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий холбогдох байгууллагаас авсан,
- Сүүлийн 1 жилийн /улирлын/ санхүүгийн тайлан,
- Зээлийн барьцаанд өөрийн өмчлөлийн эсхүл гуравдагч этгээдийн барьцааны зүйлийг тавих, батлан даалт, банкны баталгаатай,
- Чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх
- Хөрөнгө оруулалтын нийт төсвийн 30 хувиас багагүй хэмжээг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай /хөрөнгө оруулалтын зээлийн хувьд/

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бизнес эрхлэгч эмэгтэйчүү-дийг дэмжих зээл* | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 200.0 сая төгрөг хүртэл | 500.0 сая төгрөг хүртэл | Уян хатан |
| **Хугацаа** | 40 сар хүртэл | 40 сар хүртэл; | ₮: 96 сар хүртэл; $: 36 сар хүртэл |
| **Хүү /Жилийн/** | ₮: 15.6% | ₮: 19.2% -22.8%; $: 18.0% -21.6%; | ₮: 21.6% -24.0%; $: 16.8% -20.4%; |
| **Өргөдлийн хураамж** | 5,000 төгрөг | 10,000 төгрөг, 10 ам.доллартой тэнцэх төгрөг | 15,000 төгрөг, 15 ам.доллартой тэнцэх төгрөг |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | Олгосон зээлийн 1% | Олгосон зээлийн 1% буюу 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй, 3,000 ам.доллароос хэтрэхгүй. | Олгосон зээлийн 1% буюу 3.0 сая төгрөгөөс хэтрэхгүй, 3,000 ам.доллароос хэтрэхгүй. |

** Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийн нэмэлт шалгуур:*

- *Хувиараа бизнес эрхлэгч эмэгтэй байх*
- *Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 50 болон түүнээс дээш хувийг эмэгтэй хувьцаа эзэмшигч эзэмшдэг, гүйцэтгэх удирдлага нь эмэгтэй байх*
- *Нөхөрлөлийн гишүүдийн 50%-аас дээш хувь нь эмэгтэй гишүүд байх*
- *Хоршооны гишүүдийн 50%-аас дээш хувь нь эмэгтэй гишүүд байх, эсвэл хоршооны дарга нь эмэгтэй гишүүн байх*
- *Сүүлийн 6 сарын турш тасралтгүй бизнес эрхэлсэн туршлагатай байх*
- *Нөхөрлөл, хоршооны хувьд аль нэг гишүүн нь сүүлийн 6 сар тухайн бизнесийг эрхэлсэн туршлагатай байх*

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

### Иргэн

- Зээл хүсэгч болон хамтран зээл хүсэгчийн иргэний үнэмлэх,
- Орлого баталгаажуулах баримт бичиг,
- Барьцааны зүйлийн бичиг баримт, лавлагаа, итгэмжлэл, зөвшөөрөл,
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримт,
- Зээлийн зориулалтын мэдээлэл, гэрээ, төсөл, эргэн төлөлтийн хуваарь,
- Бусад банк, банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/-д зээлийн үлдэгдэлтэй бол зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ, дансны хуулга.
- Бусад шаардлагатай нэмэлт материалууд

### Хуулийн этгээд

- Зээл хүссэн албан хүсэлт
- Компанийн гэрчилгээний хуулбар
- Компанийн дүрмийн хуулбар
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримт
- Зээлийн зориулалтын талаар мэдээлэл, гэрээ, төсөл гэх мэт
- Татварын албаны тодорхойлолт
- Компанийн санхүүгийн тайлан
- Барьцаалах хөрөнгийн бичиг баримт/эх хувь/
- Зээл авах болон хөрөнгө барьцаалах тухай ТУЗ /ХНХ/-ийн тогтоол
- Бусад шаардлагатай нэмэлт материалууд

__Төрийн банкнаас олгож буй нийт зээлүүд__:

*Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл, Зээлийн шугам, Зоорь барих, засварлах болон худалдан авах зээл, Тээврийн бизнесийн зээл, Үл хөдлөх хөрөнгө худалдан авах зээл, Гараны бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл, Гараны бизнесийн хөрөнгө оруулалтын зээл, АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл, Газар тариалангийн дамжуулан олгох зээл, Эх үүсвэртэй батлан даалттай төслийн зээл, Улаан буудай, тосны ургамал худалдан авах зээл, ЖАЙКА Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл, Репо арилжааны санхүүжилттэй зээл зэргийг олгож байна.*

***УЛААНБААТАР:** Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага Тойруу 7/1*

***БУЛГАН:** Булган аймаг, 5-р баг 5-р хороо Магсаржавын гудамж, Төрийн банкны байр*

***ОРХОН:** Баян-Өндөр сум, Уурхайчин баг Төрийн Банкны Байр*

***ХОВД:** Жаргалант сум, Магсаржав баг Ард-Аюушийн талбайн баруун талд*

***1800-1881***

***info@statebank.mn***
***www.statebank.mn***

германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Капитрон банк –Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**ПОС-ын орлого барьцаалсан зээл:** Банкны ПОС төхөөрөмж эзэмшигчдийн богино хугацааны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор ПОС-ын орлогыг барьцаалан олгох зээлийн бүтээгдэхүүн.
**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Иргэдийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулсан зээлийн бүтээгдэхүүн.
**Хөрөнгө оруулалтын зээл:** Иргэдийн бизнесээ өргөжүүлэх, шаардлагатай үндсэн хөрөнгө болон тоног төхөөрөмж худалдан авах, үйлдвэрлэл үйлчилгээний барилга барих, засварлахад зориулан олгох зээлийн бүтээгдэхүүн.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Пос-ын орлого барьцаалсан зээл:**

- ПОС эзэмших гэрээтэй байх
- Бизнесээ 12 сараас дээш хугацаанд тасралтгүй эрхэлсэн байх
- ПОС машин ашигладаг байх
- Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн үлдэгдэлгүй
- Шаардлагатай тохиолдолд батлан даагч болон нэмэлт барьцаа хөрөнгө гаргах
- Бусад

**Бусад зээл:**

- 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх
- Бизнесээ 12 сарын хугацаанд тогтвортой эрхэлсэн байх
- Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй, чанаргүй зээлийн түүхгүй байх
- Банкны шаардлага хангасан барьцаа хөрөнгөтэй эсвэл батлан даагчтай байх
- Бусад

**Санхүүгийн түшиг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн нэмэлт шаардлага**

- Цалингийн орлоготой бол тухайн байгууллагад сүүлийн 6 сар тасралтгүй ажилласан үндсэн ажилтан байх;
- Бизнесийн орлоготой бол тухайн бизнесийн үйл ажиллагааг 6 сар тасралтгүй эрхэлсэн байх;
- Хамтран үүрэг гүйцэтгэгчтэй байх;
- Хамтран үүрэг гүйцэтгэгч нь сүүлийн 3 сар тогтвортой хөдөлмөр, бизнес эрхэлсэн, тогтмол орлоготой байх;

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | ПОС-ын орлого барьцаалсан зээл | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл | Санхүүгийн түшиг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл |
|---|---|---|---|---|
| **Хэмжээ** | 30.0 сая төгрөг хүртэл | 500 сая төгрөг хүртэл, түүнтэй тэнцэх ам.дол | Өөрийн хөрөнгийн 20% хүртэл | 100 сая төгрөг хүртэл, түүнтэй тэнцэх ам.дол |
| **Хугацаа** | 30 сар хүртэл | 24 сар хүртэл | 60 сар хүртэл | 18 сар |
| **Хүү /Сарын/** | ₮: 1.6% - 1.7% | ₮: 1.6%-2.0%<br>$: 1.1%-1.5% | ₮: 1.6%-2.0%<br>$: 1.1%-1.5% | ₮: 1.6%-1.9%<br>$: 1.0%-1.4% |
| **Хүү /Жилийн/** | ₮: 19.2%-20.4% | ₮: 19.2%-24.0%<br>$: 13.2%-18.0% | ₮: 19.2%-24.0%<br>$: 13.2%-18.0% | ₮: 19.2%-22.8%<br>$: 12.0%-16.8% |
| **Өргөдлийн хураамж** | 5,000 төгрөг | 5,000 төгрөг | 5,000 төгрөг | 10,000 төгрөг |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл** | 0.5% | 0.5% | 0.5%-0.8% | 0.5%-1.0% |

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

| ПОС-ын орлого барьцаалсан зээл | Бусад зээл |
|---|---|
| • Зээл хүссэн өргөдөл /Энд дарж татна уу/<br>• Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэхний эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан хуулбар<br>• Бизнесийн орлого тодорхойлох баримтууд<br>• Бусад банк болон ББСБ-уудад зээлийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга<br>• Барьцаа хөрөнгийн баримт бичгүүд<br>• Бусад шаардлагатай материал | • Зээл хүссэн өргөдөл /Энд дарна уу/<br>• Зээл хүсэгчдийн иргэний үнэмлэх /Нотариатаар баталгаажуулсан хуулбар эсвэл эх хувиар/<br>• Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотой хийсэн гэрээ хэлцлүүд<br>• Бизнесийн орлого тодорхойлох баримтууд /ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл, бизнесийн гэрээ хэлцлүүд, орлогын бүртгэлийн дэвтэр, дансны хуулга гэх мэт/<br>• Бусад банк болон ББСБ-уудад зээлийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга<br>• Барьцаа хөрөнгийн баримт бичгүүд<br>• Бусад шаардлагатай материал |

## Капитрон банкнаас олгож буй нийт зээлүүд:

Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл, ПОС-ын орлого барьцаалсан зээл, Санхүүгийн түшиг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл, Саарал усны тоног төхөөрөмжийн зээл, Ногоон бизнесийн зээл, Хосолсон хөдөлгүүрт автомашины зээл, Малчны зээл зэрэг зээлүүдийг олгож байна.


***УЛААНБААТАР:*** *Сүхбаатар дүүрэг, Усны гудамж - 4, Улаанбаатар-14253, Төв банкны байр*

***ОРХОН:*** *Баян-Өндөр сум, Амарын өргөн чөлөө, Хүрэн булаг баг.*

***ХОВД:*** *Жаргалант сум, Баатархайрхан баг, Үйлдвэрийн район, Их буян худалдааны төв.*

***1800-2020***

***capitronbank@gmail.com***
***www.capitronbank.mn***

# Тээвэр хөгжлийн банк – Бизнесийн зээл

**ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ**

**Жижиг дунд бизнесийн зээл-репо:** Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч болон уул уурхайн бус экспортын салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийг дэмжихэд зориулсан.

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Үйл ажиллагааны орлого, ашиг аа нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах, төрлөө нэмэгдүүлэх, шаардлагатай санхүүгийн хэрэгцээгээ бүрэн хангах

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнесийн үйл ажиллагаагаа өргөтгөх зорилгоор үндсэн хөрөнгө худалдан авах, барилга байгууламж барих, өргөтгөх, техник технологи болон тоног төхөөрөмж худалдан авах

**ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Сүүлийн 12 сар тасралтгүй бизнес явуулсан туршлагатай;
- Зээлийн сайн түүхтэй зээл төлөх чадвар сайтай байх;
- Барьцаат хөрөнгө (үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө)-ийн шаардлага хангасан байх;
- Банкнаас тавьсан бусад шаардлага хангах.

**Жижиг дунд бизнесийн репо зээлийн нэмэлт шаардлага:**

- Репо санхүүжилтийн эх үүсвэрийг олгож буй Монголбанкнаас тавьсан шалгуурыг хангасан байх;
- ЖДҮ, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд заасны дагуу буюу 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой иргэн, ААН байх
- Уул уурхайн бус экспорт, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ*, 200 болон түүнээс дээш ажилтантай бөөний болон жижиглэн худалдааны салбар

**ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ**

| Төрөл | Жижиг дунд бизнесийн репо зээл | Эргэлтийн хөрөнгийн зээл* | Хөрөнгө оруулалтын зээл* |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 3 тэрбум төгрөг хүртэл | Уян хатан | Уян хатан, Хөрөнгө оруулалтын 30 хувийг өөрөө санхүүжүүлнэ. |
| **Хугацаа** | 24 сар хүртэл | 36 сар хүртэл | 60 сар хүртэл; 36 сар хүртэл |
| **Хүү /Сарын/** | | ₮: 1.6% - 2.0%<br>$: 0.85% - 1.2% | ₮: 1.6% - 2.2%<br>$: 0.85% - 1.2% |
| **Хүү /Жилийн/** | ₮: 10.5% /репо арилжааны хүү+4 нэгж хувиас хэтрэхгүй/ | ₮: 19.2% - 24.0%<br>$: 10.2% - 14.4% | ₮: 19.2% - 24.0%<br>$: 10.2% - 14.4% |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | 1% буюу 1,500,000 төгрөгөөс хэтрэхгүй | 1% буюу 1,500,000 төгрөг<br>0:5% буюу 1,500 ам.доллар | 1% буюу 1,500,000 төгрөг<br>0.5% буюу 1,500 ам.доллар |
| **Өргөдлийн хураамж** | 30,000 төгрөг | 30,000 төгрөг | 30,000 төгрөг |

*үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа – 12 сар хүртэл /репо санхүүжилтийн зээлийн хувьд 6 сараас багагүй/
*Нэмэгдүүлсэн хүү нь үндсэн хүүгийн 20%-тай тэнцүү
*Эргэлтийн хөрөнгийн болон Хөрөнгө оруулалтын зээлийг Евро, Юань, Иен-ээр авах боломжтой.

**БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

- Зээл хүссэн албан бичиг
- Зээлийн өргөдөл /банкны маягтаар/
- Зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол
- ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Байгууллагын дүрэм, танилцуулга
- Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, бизнес төлөвлөгөө, бусад баримт бичиг
- Зээлийн зориулалтын талаар мэдээлэл, гэрээ, төсөл
- Зах зээл болон өрсөлдөгчдийн талаарх мэдээлэл
- Татварын албан тодорхойлолт
- ШШГЕГ-ын тодорхойлолт
- УБЕГ-ын лавлагаа
- Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан – сүүлийн 4 улирлаар
- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн сүүлийн жилийн эцсийн байдлаарх дэлгэрэнгүй
- Дансны хуулга – сүүлийн 12 сарын байдлаар
- Барьцаалах хөрөнгийн гэрчилгээ
- Бусад банк болон ББСБ-д зээлийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга
- Бусад шаардлагатай нэмэлт материалууд

***УЛААНБААТАР:*** ***Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 19А, Шангри-Ла оффис, 15 давхар***

***7716-9999***

***secretary@transbank.mn***
***www.transbank.mn***

# Богд банк –Бизнесийн зээл

### ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл:** Бичил, жижиг бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжих, тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг санхүүжүүлэх

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Бизнесийн үйл ажиллагаандаа зориулан бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнесээ өргөтгөх, шинэчлэх, шинээр бизнес эхлэхэд зориулан газар, барилга, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх дунд хугацааны хөрөнгө оруулалтын зээлийн үйлчилгээ

**Репо санхүүжилтийн зээл:** Уул уурхайн бус экспортын салбар болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн бизнесээ өргөжүүлэх хэрэгцээг хангах.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүй, сүүлийн 3 жилийн хугацаанд чанаргүй зээлийн түүхгүй байх

Сүүлийн 2 жил үйл ажиллагаа нь хэвийн явагдсан

Бизнесийн тогтмол урсгалтай байх

Зээлийн баталгаа болохуйц барьцаа үл хөдлөх хөрөнгөтэй байх

Тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан, зөвшөөрөл нь зээл төлөгдөж дуусах хүртэл хүчин төгөлдөр байх эсхүл тодорхой хугацаагаар олгогддог тусгай зөвшөөрлийн хувьд цаашид сунгагдах боломжтой байх

### ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Репо санхүүжилтийн зээл | Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих зээл | Эргэлтийн хөрөнгийн зээл* | Хөрөнгө оруулалтын зээл |
|---|---|---|---|---|
| **Хэмжээ** | 3 тэрбум төгрөг хүртэл | 50.0 сая төгрөг хүртэл | Уян хатан | Уян хатан |
| **Хугацаа** | 30 сар хүртэл | 36 сар хүртэл | 36 сар хүртэл | 60 сар хүртэл |
| **Хүү /Сарын/** | | ₮: 1.8% - 2.2% | ₮: 1.8% - 2.3%<br>$: 1.2% - 1.6% | ₮: 1.9% - 2.4%<br>$: 1.2% - 1.6% |
| **Хүү /Жилийн/** | ₮: 19.0% | ₮: 21.6% - 26.4% | ₮: 21.6% - 27.6%<br>$: 14.4% - 19.2% | ₮: 22.8% - 28.8%<br>$: 14.4% - 19.2% |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /1 удаа/** | 1%-2% | 0.4%-1% | 0.4%-1% (төгрөг)<br>0.5% (ам.доллар) | 0.4%-1% (төгрөг)<br>0.5% (ам.доллар) |
| **Өргөдлийн хураамж** | 10,000 төгрөг | 10,000 төгрөг | 10,000 төгрөг | 10,000 төгрөг |

*Зээлийн шугам – Сарын хүү 1.9%-2.3%, үүрэг хүлээсний шимтгэл жилийн 3-6%, хугацаа нь 24 сар хүртэл. Бусдаар Эргэлтийн хөрөнгийн зээлтэй ижил нөхцөлтэй.

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

**Репо санхүүжилтийн зээлийн хувьд**

- Зээлийн өргөдөл (Богд банкны маягтаар)
- ААН, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, Байгууллагын дүрэм, танилцуулга
- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
- Зээл авах тухай ТУЗ-ын зөвшөөрөл, хувь нийлүүлэгчдийн хурлын протокол
- Эрх бүхий албан тушаалтны иргэний үнэмлэх
- Ажлын байрын бичиг баримт/ түрээсээр ашигладаг бол түрээсийн гэрээ, сүүлийн 6 сарын түрээс төлсөн баримт/
- Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд
- Аудит, татварын албаар баталгаажуулсан тайлан болон бусад орлого, зарлагыг нотлох баримтууд
- Зээлийн зориулалтыг баталгаажуулсан баримт, түүнтэй холбоотойгоор хийгдсэн гэрээ хэлцэл
- Сүүлийн 3 жилийн хугацааны зээлийн түүхийг баталгаажуулсан баримтууд, зээлийн гэрээ, төлбөр төлсөн баримтууд
- Банкны зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт материал

**Бусад зээлийн хувьд**

- Зээлийн өргөдөл (Богд банкны маягтаар)
- Компанийн болон бизнесийн танилцуулга
- Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, үүсгэн байгуулсан гэрээ
- Санхүүгийн тайлан (сүүлийн 3 жил/ улирлын тайлан)
- Бизнесийн үйл ажиллагааны зөвшөөрөл, лиценз, патент
- Зээлээр санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцэл
- Барьцаа хөрөнгөтэй холбоотой бичиг баримтууд
- Бизнесийн онцлогоос шалтгаалан шаардагдах бусад бичиг баримт, тооцоо судалгаа, мэдээлэл г.м

*УЛААНБААТАР*
*Бодь цамхаг, Чингэлтэй дүүрэг,*
*1-р хороо, Жигжиджавын гудамж 3*

*7577-1199*

*info@bogdbank.com*
*www.bogdbank.com*

германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Ариг банк –Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зориулсан зээл юм.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнесийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж авах зориулалтаар олгогдох зээл.

**Бизнесийн зээлийн шугам:** таны бизнес улирлын чанартай, гэнэтийн санхүүгийн асуудалтай тулгардаг бол энэхүү зээл маш тохиромжтой.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Тухайн бизнесийг сүүлийн 1 жил тасралтгүй эрхэлсэн туршлагатай,
- Зээлийн баталгаа болохуйц барьцаа үл хөдлөх хөрөнгөтэй байх,
- Бусад банк болон ББСБ-д хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх,
- Зээлээ үр ашигтай ашиглах чадвартай, боломжтой байх*
- Бизнесийн үр ашгийн тооцооллоо хийж, хөтөлдөг байх*
- Хэрвээ тусгай зөвшөөрөл шаарддаг бизнес эрхэлдэг бол холбогдох зөвшөөрөл, лицензүүдийг авсан байх*

*Хөрөнгө оруулалтын зээлийн хувьд нэмж тавигдах шаардлагууд

## БАРЬЦАА ХӨРӨНГӨ

- Амины болон нийтийн эзэмшлийн орон сууц,
- Компанийн өмчлөлийн болон хувийн эзэмшлийн барилга, объектууд,
- Хашаа байшин, газрын хамт.

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бизнесийн зээлийн шугам | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 2 тэрбум төгрөг хүртэл | 2 тэрбум төгрөг хүртэл | 500 сая төгрөг хүртэл |
| **Хугацаа** | 24 сар хүртэл | 36 сар хүртэл | 60-120 сар хүртэл; |
| **Хүү /Сарын/** | ₮: 1.6%-1.9%<br>$: 1.1%-1.5% | ₮: 1.6%-1.9%<br>$: 1.1%-1.5% | ₮: 1.6%-1.9%;<br>$: 1.1%-1.5% |
| **Хүү /Жилийн/** | ₮: 19.2%-22.8%<br>$: 13.2%-18% | ₮: 19.2%-22.8%<br>$: 13.2%-18% | ₮: 18.6%-24%<br>$: 13.2%-18% |
| **Нэмэлт нөхцөл** | Ашиглаагүй үлдэгдлийн хүү 4% Зээлийн эрхийн хэмжээгээр зээл авах, буцаан төлөх, төлсөн хэмжээгээр дахин зээл авах боломжтой. | Зээлийн хугацааны 1/3-т нь үндсэн зээлээс чөлөөлж болно | Эхний 12 хүртэл сард үндсэн зээлийн төлөлтөөс чөлөөлөх боломжтой. |

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Зээл хүсэгчийн анкет /Банкны маягтаар/
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Үйл ажиллагааны талаарх танилцуулга
- Бизнестэй холбоотой бичиг баримтууд
- Зээлээр санхүүжүүлэх бизнес төлөвлөгөө /үр ашгийн тооцоо/
- Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгийн нотариатаар баталгаажуулсан гэрчилгээний хуулбар /ҮХЭХБГазрын зээлийн барьцаанд байхгүй тухай лавлагааны хамт/
- Зээлийн судалгаанд ашиглагдах бусад шаардлагатай бичиг баримтууд

**Ариг банкнаас олгож буй нийт зээлүүд:**

*Эргэлтийн хөрөнгийн зээл, Хөрөнгө оруулалтын зээл, Бизнесийн зээлийн шугам, “АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөл”-ийн зээл, Ханган нийлүүлэгчийн зээл, "Нийслэлийн жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв"-тэй хамтран жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих түр зээл зэргийг олгож байна.*

***УЛААНБААТАР***
***Хан-Уул дүүрэг***
***Чингисийн өргөн чөлөө,***
***Ариг Банкны байр***

***7013-3060***

***info@arigbank.mn***
***www.arigbank.mn***

# Чингис хаан банк –Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Эргэлтийн хөрөнгийн зээл:** Байгууллага, аж ахуйн нэгжийн бизнесийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор бараа материал худалдан авах болон бизнесийн үйл ажиллагааны ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах зориулалтаар олгогдоно.

**Хөрөнгө оруулалтын зээл:** Бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авах болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй байраа шинэчлэх, засварлах, худалдан авах, өргөтгөх зэрэг зориулалтаар олгогдох зээл.

**Зээлийн шугам:** Батлагдсан зээлийн эрхийн хэмжээ болон хугацааны хүрээнд эргэлтийн хөрөнгийн хэрэгцээнээс хамаарч олгогдох эргэн төлөлтийн уян хатан нөхцөл бүхий зээл.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бизнес эрхэлсэн туршлагатай байх;

Зээлээ эргэн төлөх чадвартай байх;

Нийт хөрөнгө оруулалтын тодорхой хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байх.

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Эргэлтийн хөрөнгийн зээл | Хөрөнгө оруулалтын зээл | Зээлийн шугам |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | уян хатан тогтооно | уян хатан тогтооно | уян хатан тогтооно |
| **Хугацаа** | 30 хүртэл сар | 60 хүртэл сар | 24 хүртэл сар |
| **Хүү /Жилийн/** | ₮: 20.4% - 24.0%<br>$: 13.2% - 18.0% | ₮: 20.4% - 24.0%<br>$: 13.2% - 18.0% | ₮: 20.4% - 24.0%<br>$: 13.2% - 18.0%<br>Коммитмент хүү:<br>₮: 3,6% $:1,8% |
| **Өргөдлийн хураамж** | 10,000 төгрөг | 10,000 төгрөг | 10,000 төгрөг |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | 0.5% (5,000,000 төгрөг буюу түүнтэй тэнцэх ам.доллар) | 0.5% (5,000,000 төгрөг буюу түүнтэй тэнцэх ам.доллар) | 0.5% (5,000,000 төгрөг буюу түүнтэй тэнцэх ам.доллар) |

*Зээлийн бодит өртөг (жилийн): **₮:** 22.62%-27.11%, **$:**14.11%-19.72%,

Зээлийн хугацаа сунгах : 0.5% (5,000,000 төгрөг буюу түүнтэй тэнцэх ам.доллар)

Бусад нөхцөлд өөрчлөлт оруулах: 100,000 төгрөг

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

**Аж ахуйн нэгж**

- Зээл хүссэн албан хүсэлт;
- Компанийн гэрчилгээний хуулбар;
- Компанийн дүрмийн хуулбар;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой тусгай зөвшөөрөл, бусад бичиг баримт;
- Зээлийн зориулалтын талаар мэдээлэл, гэрээ, төсөл гэх мэт
- Татварын албаны тодорхойлолт;
- Компанийн санхүүгийн тайлан;
- Барьцаалах хөрөнгийн бичиг баримт/эх хувь/;
- Зээл авах болон хөрөнгө барьцаалах тухай ТУЗ /ХНХ/-ийн тогтоол;
- Бусад шаардлагатай нэмэлт материалууд;

*УЛААНБААТАР:*
*Чингисийн өргөн чөлөө - 15, Нью Сенчьюри Плаза*

*1800-1300*

*bank@ckbank.mn*
*www.ckbank.mn*

# Инвескор ББСБ –Бизнесийн зээл

### ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр:** Инвескор ББСБ ХК, Риотинто Монгол ХХК хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хамтарсан хөтөлбөр.

**Бизнесийн зээл:** Жижиг дунд бизнес эрхлэгчдийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөхөд зориулсан зээл.

**Бизнесийн зээлийн шугам:** Зээлийн төлбөрөө хугацаанд нь төлдөг, эргэлтийн хөрөнгийн санхүүжилт тогтмол шаардагддаг зээлдэгчдэд зээлийн шугамын эрх нээж, санхүүжилтийн хамгийн таатай нөхцөлүүдийг санал болгодог.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Барьцаа хөрөнгө болон орлого хүрэлцэхүйц байх
- 6 болон түүнээс дээш сар үйл ажиллагаа явуулсан байх

### БАРЬЦАА

Автомашин, Орон сууц, Оффис, Үйлчилгээний талбай, Авто зогсоол, Хашаа байшин, Нээлттэй компанийн хувьцаа, Гэрчилгээтэй машин механизм /бүх зээлэнд барьцаалж болно./

Нээлттэй компанийн хувьцаа, Гэрчилгээтэй машин, механизм ЖДҮ дэмжих хөтөлбөрт хамаарахгүй.

### ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр | Бизнесийн зээл | Бизнесийн зээлийн шугам |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 30 сая төгрөг хүртэл | 2 тэрбум төгрөг хүртэл | 30 сая – 2 тэрбум төгрөг хүртэл |
| **Хугацаа** | 24 сар | 36 сар | 24 сар |
| **Хүү /Сарын/** | 0.4% | 2.9%-3.2% | 2.9%-3.2% |
| **Хүү /Жилийн/** | 4.8% | 34.8%-38.4% | 34.8%-38.4% |
| **Шийдвэрлэх хугацаа** | 72 цаг | 4-5 өдөр | 4-5 өдөрг |

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Орлого тодорхойлох бичиг баримтууд
- Барьцаа хөрөнгийн мэдээлэл
- Хэрэв хуулийн этгээд бол гэрчилгээ, дүрэм, бусад холбогдох материалыг бүрдүүлнэ.

### ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ШААРДЛАГА, БҮРДҮҮЛЭХ МАТЕРРИАЛ

| Тавигдах шаардлага | Бүрдүүлэх материал |
|---|---|
| • Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг Улаанбаатар хотын харьяалалтай иргэн, аж ахуйн нэгж байх.<br>• Зээл төлөх орлогын эх үүсвэрийг бүрдүүлж буй бизнесийг сүүлийн 6 сараас доошгүй хугацаанд тогтвортой эрхэлж байгаа бөгөөд цаашид эрхлэх боломжтой байх.<br>• Зээл хүсэгчийн бизнесийн үйл ажиллагаа нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулахааргүй байх<br>• Инвескороос тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх.<br>• Зээлийн барьцаа хөрөнгийн шаардлагыг хангасан байх.<br>• Зээлийн мэдээллийн сангийн лавлагаагаар банк болон бусад банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан үлдэгдэлтэй зээлүүдийн ангилал хэвийн байх | • Эрхэлдэг бизнесийн танилцуулга;<br>• Иргэний үнэмлэх /ААН гэрчилгээ, дүрэм/;<br>• Бизнес төлөвлөгөө эсвэл зээлийн зарцуулалт үр ашгийн тооцоо санхүүжилт авахтай холбоотой гэрээ, хэлцэл, баримтууд;<br>• Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, лиценз, холбогдох баримтууд;<br>• Орлого, зарлагыг нотлох баримтууд;<br>• Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, тайлантай холбоотой тодруулгай тайлангууд;<br>• Зээлийн барьцаанд барьцаалах хөрөнгийн гэрчилгээ, лавлагаа;<br>• Сүүлийн 2 жил доторх банк болон бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн гэрээ, барьцааны гэрээ, зээлийн дансны хуулга. |
| **Дэмжих бизнесийн чиглэл** | **Хориглох бизнесийн чиглэл** |
| • Импортыг орлох дотоодын бүтээгдэхүүний бизнес<br>• Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний бизнес<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес<br>• Өрх толгойлсон эцэг, эхийн бизнес | • Уул уурхай, байгаль орчинд хор хөнөөлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдаалагч<br>• Архи, пиво согтууруулах ундаа үйлдвэрлэгч, худалдаалагч<br>• Тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэгч, худалдаалагч<br>• Бооцоот болон мөрийтэй тоглоомын үйлчилгээ үзүүлэгч |


***УЛААНБААТАР:** 13 давхар, Төвп тауэр-1, Сөүлийн гудамж 10/1, 2 хороо, СБД, Улаанбаатар хот /Оросын элчин сайдын яамны урд/*

***ОРХОН:** Эрдэнэт хот, Уурхайчин баг, 3-р хороолол, 22-р байр*

***7709-0077***

***info@invescore.mn***
***www.invescore.mn***

# Транс капитал ББСБ –Бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

**Бүлгийн зээл:** Хувиараа бизнес эрхлэгч 3-5 гишүүнтэй, бүлгийн батлан даалттай, барьцаагүй, бизнесийн болон хэрэглээний зориулалттай олгогддог зээл юм.

**Бичил бизнесийн зээл:** Бичил бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, урт хугацаатайгаар, барьцаатай болон барьцаагүй /үл хөдлөх хөрөнгө барьцаалахгүй боловч хөдлөх хөрөнгө барьцаална/ зээл авах боломжтой.

**Жижиг дунд бизнесийн зээл:** Жижиг дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалт хийхэд зориулсан зээл.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байх

Барьцаа хөрөнгөтэй байх: орон сууц, хашаа байшин, газар, хөдлөх хөрөнгө

“Барьцаагүй зээл” төрлийн зээлэнд хөдлөх хөрөнгө барьцаалах шаардлагатай.

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Орлого нотлох баримт
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ /ҮХХ бол ТҮЦ машинаас лавлагаа/
- Зээлтэй бол зээлийн дансны хуулга

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Бүлгийн зээл* | Бичил бизнесийн зээл | Жижиг дунд бизнесийн зээл |
|---|---|---|---|
| **Хэмжээ** | 500 мянган төгрөгөөс 3,0 сая төгрөг хүртэл | 35.0 сая төгрөг хүртэл /бизнесийн зориулалттай автомашин худалдаж авах бол 100,0 сая төгрөг хүртэл/ | 500.0 сая төгрөг хүртэл |
| **Хугацаа** | 12-30 сар | 36 сар хүртэл | 60 сар хүртэл |
| **Хүү /Сарын/** | ₮: 2.80% - 3.00% | ₮: 2.5% - 3.00% | ₮: 2.2%-2.9%; |
| **Хүү /Жилийн/** | ₮: 33.60% - 36.00% | ₮: 30.0% - 36.00% | ₮: 26.4% - 34.8% |
| **Зээл олгох үйлчилгээний шимтгэл /хувь, дээд хэмжээ/** | 1% хүртэл | 1% хүртэл | 0.5% хүртэл |

*Бүлгийн гишүүдийн тоо: 3-5 хүн


***УЛААНБААТАР:***
*Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Партизаны гудамж, Транскапитал ББСБ-ын байр*

***ОРХОН:***
*Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, 4 хороолол, 20 байр, 75 тоот*

***ХОВД:***
*Жаргалант сум, Алагтолгой баг, Орчлон плаза төв*

***11-332255***
***7011-1000***

***contact@transcapital.mn***
***www.transcapital.mn***

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Ард кредит ББСБ – Жижиг дунд бизнесийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

Жижиг дунд бизнесүүдийг дэмжих зориулалттай бүтээгдэхүүн

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Хэрэглэгчийн application form /NBFI application хэлбэрээр/
- Зээлийн application /NBFI application хэлбэрээр/
- Зээл хүсэгчийн цээж зураг
- Иргэний үнэмлэх
- Барьцаа хөрөнгийн бичиг баримт
- Орлогын хэмжээг батлах бичиг баримт
- Бусад /шаардлагатай тохиолдолд/

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Төрөл | Жижиг дунд бизнесийн зээл | Зээлийн шугам |
|---|---|---|
| **Хэмжээ** | 2-500 сая төгрөг | 2-500 сая төгрөг |
| **Хугацаа** | 12-36 сар | 12-36 сар |
| **Хүү /сарын/** | ₮: 2.4% - 2.8% | ₮: 2.4% - 2.8% |

## ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ ХАРИУЛТ

- **Зээлийн хүсэлт гаргах**

http://bit.ly/BusinessArdFinancialGroup вэб хаягаар үйл ажиллагааны талаар мэдээлэл, орлого, өр төлбөрийн мэдээлэл, ямар зориулалтаар, хэдий хэмжээний зээл хүсч байгаа тухай мэдээлэл илгээнэ.

- Хамрагдах боломжтой хувь хүн болон хуулийн этгээд

Үйл ажиллагаа тогтвортой явагдаж буй, зээлийн төлбөр эргэн төлөгдөх орлого нотлогдох, зээлийн хэмжээнд хамаарах барьцаа хөрөнгийн шаардлага хангасан байх

- **Өвөл зогсолттой байдаг бизнес авч болох уу?**

**Болно, улирлын чанартай бизнесийн орлого зогсонги үед үндсэн зээлээс тухайн хугацаанд чөлөөлөгдөх боломжтой.**

- **Зээлийн барьцаа**

**Үл хөдлөх хөрөнгө, хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгө барьцаалж болно**

- **Бизнесийн орлогоо нотлох**

**Байгууллага бол санхүүгийн тайлан, идэвхтэй үйлчилгээ борлуулалтын гэрээгээр. Хувь хүн бол хар дэвтэр, банкны дансны хуулга**


***УЛААНБААТАР***

***Сүхбаатарын талбай - 2,
Сэнтрал Тауэр барилгын 13 давхар, 1313 тоот.***

***77003322***

***info@ardcredit.com***

# Жижиг дунд үйлдвэрийн сангийн зээл

## ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

Экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжих, шинээр бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох зээл юм. Зээлийг Засгийн газрын 2020 оны 113-р тогтоолоор батлагдсан “ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам“-ын дагуу олгоно.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан байгууллагад бүртгүүлж, тодорхойлолт авсан аж ахуйн нэгж төсөл сонгон шалгаруулалтанд оролцох эрхтэй.
- Зээлд хамрагдах төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт сайжруулалт, дуусгавар болох хугацаар тодорхой заасан байна.
- Төслийн нийт хөрөнгө оруулалтын 30-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлэх
- Барьцаа хөрөнгөтэй байх /эсвэл Зээлийн батлан даалтын сангийн батлан даалт/

## ХЭРХЭН ТӨСЛИЙН САНАЛАА ХҮРГҮҮЛЭХ ВЭ?

Төсөл хүлээн авах товыг Жижиг, дунд үйлдвэрийн газар тогтоож, олон нийтэд зарлана /2023 онд харьцангуй эрт, 2-р сард зарласан/.

Товыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлаж, 30 хоногийн хугацаанд төслийн саналы хүлээн авна.

## ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

| Ангилал | Зээл олгох хэлбэр | Борлуулалтын орлого /төгрөг/ | Зээлийн дээд хэмжээ* (төгрөг) |
|---|---|---|---|
| Бичил | Сангаас шууд олгох | 0-100,0 сая хүртэл | 100,0 сая хүртэл |
| | | 100,0-200,0 сая хүртэл | 200,0 сая хүртэл |
| | | 200,0 саяас дээш | 300,0 сая хүртэл |
| Жижиг | Банкаар дамжуулан олгох | 300,0 саяас дээш | 1,0 тэрбум хүртэл |
| Дунд | | 1,0-2,5 тэрбум хүртэл | 2,5 тэрбум хүртэл |

| Ангилал | Зээлийн нөхцөл |
|---|---|
| **Зээлийн хэмжээ** | Доод хэмжээ: 20 сая төгрөг<br>Дээд хэмжээ: дээрх хүснэгтийн дагуу |
| **Зээлийн хүү** | Сангаас шууд олгох: 3%<br>Банкаар дамжуулан зээлдэх: тухайн банкны ЖДҮ-ийн зориулалттай зээлийн хүүний доод түвшингээс бага байх |
| **Зээлийн хугацаа** | 5 хүртэл жил |
| **Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа** | 12 хүртэл сар |
| | |

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- Зээлийн өргөдөл (Сангаас баталсан загварын дагуу);
- Захирлын иргэний үнэмлэхийн хуулбар;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шаардлагатай бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- Хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, үүсгэн байгуулагчийн дэлгэрэнгүй лавлагаа;
- Барьцаалах үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн болон эзэмших эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, газрын гэрээ, кадастрын зургийн хуулбар;
- Хэрэв зээлийн хэвийн үлдэгдэлтэй бол зээлийн гэрээ, зээлийн дансны баталгаажсан хуулга, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн хуулбар;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан (хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс);
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тухайн жилийн тодорхойлолт;
- Нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн даатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт;
- Төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт;
- Төлсөн татварын хэмжээ болон татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх харьяа татварын албаны тодорхойлолт;
- Төслийн нийт хөрөнгө оруулалтын 30-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлэхийг нотлох баримт;
- Тухайн төсөл болон төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг зөвшөөрснийг илэрхийлсэн мэдэгдэл.

***УЛААНБААТАР***
***Баянзүрх дүүрэг,***
***Энхтайваны өргөн чөлөө***
***16а, Засгийн газрын IX байр***

***Жижиг дунд үйлдвэрийн газар***
***7748-5555***

***info@sme.gov.mn***
***www.smefund.gov.mn***

германы хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Published by giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# Биржийн бус зах зээлээс хөрөнгө босгох боломж

## БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛ /ББЗЗ/ ГЭЖ ЮУ ВЭ?

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) нь 2020 оны 12-р сарын 09-ны өдрийн 995 дугаар тогтоолоор "Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам"-ыг баталснаар, биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхлээд байна.

Биржийн бус зах зээл гэдэг нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас уян хатан нөхцөлөөр шаардлагатай хөрөнгө оруулалт татах үнэт цаасны компаниуд болон хөрөнгө оруулагчдын сүлжээ юм. Үйл ажиллагааны хувьд хөрөнгийн биржтэй төстэй боловч зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог учраас зохицуулалт, шаардлага нь уян хатан байдаг. Биржийн бус зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх ажлыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос (www.masd.mn) зохион байгуулж байна.

Биржийн бус зах зээл нь олон улсад өндөр хөгжсөн, манай улсын хувьд шинэлэг хэдий ч биржийн бус зах зээлээр санхүүжилт татах хандлага хүчтэй, хурдан нэмэгдэж байна.

## ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн эрх зүйн баримт бичигийг бүрэн дагаж мөрддөг байх;
- ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь хуульд заасан шаардлагыг хангасан байх;
- Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх;
- Өргөдөл гаргахаас өмнө нэгээс доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх. Энэ шаардлагыг компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааруулан хөнгөлж болно;
- Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байх, мөрддөггүй бол тайлбар гаргах.

## ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН /БОНДЫН/ НӨХЦӨЛ

| Төрөл | Нөхцөл |
|---|---|
| Хэмжээ | Уян хатан |
| Хугацаа | Уян хатан |
| Хүү | Уян хатан |
| Андеррайтерийн шимтгэл | Татан төвлөрүүлэх хөрөнгөөс дунджаар 2-3 % |
| Биржийн бус зах зээлийн бүртгэлийн хураамж | Татан төвлөрүүлэх хөрөнгөөс 0,05%<br>Доод хэмжээ: 2,000,000 төгрөг<br>Дээд хэмжээ: 10,000,000 төгрөг |
| Өргөдлийн хураамж | 1,000,000 төгрөг |

### Биржийн бус зах зээлээс хэрхэн хөрөнгө татан төвлөрүүлэх вэ?

Андеррайтерийн компанид хандана. Андеррайтерийн компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос андеррайтерийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй, компаниуд өрийн хэрэгсэл, хувьцаа гэх мэт үнэт цаас гаргахад зуучлан борлуулдаг компани юм. Тухайн компани өрийн хэрэгсэл гаргах ажиллагааг зохион байгуулж, татан төвлөрүүлсэн хөрөнгөөс дунджаар 2-3 орчим хувийн шимтгэл /гэрээгээр тохиролцоно/ авдаг.

Андеррайтерийн компаниудын жагсаалт болон холбоо барих мэдээллийг эндээс үзээрэй.

### Биржийн бус зах зээлийг хэн зохион байгуулдаг вэ?

Биржийн бус зах зээлийг Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо буюу үнэт цаасны чиглэлээр үйл ажиллагааны явуулж буй компаниудын мэргэжлийн холбооноос зохион байгуулдаг.

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны талаарх мэдээллийг эндээс үзээрэй. (www.masd.mn)

АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИУД ББЗЗ-ЭЭР ДАМЖИХГҮЙ ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДААС САНХҮҮЖИЛТ ТАТАХ БОЛОМЖТОЙ БАЙДАГ. ЭНЭ ТОХИОЛДОЛД, ЗӨВХӨН АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ ТӨЛӨХ БА БҮРТГЭЛИЙН БОЛОН ӨРГӨДЛИЙН ХУРААМЖ ТӨЛӨХГҮЙ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХ САЙН БОЛ УЯН ХАТАН НӨХЦӨЛӨӨР, ХУРДАН ШУУРХАЙ САНХҮҮЖИЛТ ТАТАЖ БОЛНО.

## БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Компани нь ББЗЗ-д үнэт цаасаа анх удаа болон нэмж гаргах бол ББЗЗ-ийн бүртгэлд бүртгүүлэх бөгөөд Бүртгэлийн хороонд дараах бичиг баримтыг хүргүүлнэ. Үүнд:

- Үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлт /маягтаар/;
- Үнэт цаас гаргагчийн мэдэгдэл /маягтаар/;
- Андеррайтерийн мэдэгдэл /маягтаар/;
- Андеррайтерийн дүгнэлт;
- Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
- Үнэт цаасны төслийн танилцуулга;
- Аудитын дүгнэлт;
- Хууль зүйн дүгнэлт;
- Бүртгэлийн үйлчилгээний хөлс төлсөн баримт.

*УЛААНБААТАР*
*Чингэлтэй дүүрэг,*
*Жуулчны гудамж,*
*Центр-34, #404*

*Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо*
*7012-3339*

*info@masd.mn*
*www.masd.mn*

# Зээлийн батлан даалтын сангийн батлан даалт

### ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТ

**Үндсэн батлан даалт:** Зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчид батлан даалт гаргана.

Батлан даалтын нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, банкны зээл олгох шалгуур үзүүлэлтүүдийг хангасан бол батлан даалтад хамрагдах хүсэлтээ банкаар дамжуулан гаргана.

**ББСБ-ын батлан даалт:** Батлан даалтын нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, ББСБ-ын зээл олгох шалгуур үзүүлэлтүүдийг хангасан бол батлан даалтад хамрагдах хүсэлтээ ББСБ-аар дамжуулан гаргана.

**АХБ-ны эх үүсвэртэй батлан даалт:** “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” MOH-3338 төсөл нь Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 2016-2023 онд хэрэгжинэ.

### ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн үйл ажиллагаа эрхэлдэг байх
- Нэгээс дээш жил үйл ажиллагаа явуулсан, санхүүгийн орлоготой байх
- Зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байх
- Жижиг дунд үйлдвэр эрхлэгч байх (Гэрчилгээ, тодорхойлолт)

### ХАМТРАН АЖИЛЛАДАГ БАНКУУД:

Хаан Банк | ХХБ | Голомт | Төрийн Банк | Хас Банк | Капитрон Банк

### БАТЛАН ДААЛТЫН НӨХЦӨЛ

| | Үндсэн батлан даалт | ББСБ-ын батлан даалт | АХБ-ны эх үүсвэртэй батлан даалт* |
|---|---|---|---|
| Зээлийн төрөл | Хөрөнгө оруулалтын; Эргэлтийн хөрөнгийн | Хөрөнгө оруулалтын; Эргэлтийн хөрөнгийн | Хөрөнгө оруулалтын; Эргэлтийн хөрөнгийн |
| Зээлийн дээд хэмжээ | Банкны зээлийн нөхцөлөөр | 80 сая төгрөг хүртэл | 2 тэрбум төгрөг хүртэл |
| Зээлийн хугацаа | Банкны зээлийн нөхцөлөөр | 48 сар хүртэл | 10 жилээс хэтрэхгүй |
| Зээлийн хүү | Банкны зээлийн нөхцөлөөр | ББСБ-ын зээлийн нөхцөлөөр | 8.8%-15.0% |
| Батлан даалтын хэмжээ | Зээлийн 60 хүртэл хувь | Зээлийн 60 хүртэл хувь | Зээлийн 30-60 хувь |
| Батлан даалтын дээд хэмжээ | 500 сая төгрөг | 48 сая төгрөг | 1.2 тэрбум төгрөг |
| Батлан даалтын үйлчилгээний хураамж | 10,000 төгрөг | 50,000 төгрөг | 50,000 төгрөг |
| Батлан даалтын шимтгэл | 1 жил хүртэл хугацаанд - 1% 2 жил хүртэл хугацаанд - 2% 2 жилээс дээш хугацаанд - 3% | 1 жил хүртэл хугацаанд - 1% 2 жил хүртэл хугацаанд - 2% 2 жилээс дээш хугацаанд - 3% | Батлан даалтын үлдэгдлээс жил бүр 1% |

*Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 12 сараас хэтрэхгүй

### Бүрдүүлэх материал

- Банк эсвэл ББСБ-аас албан тоот, холбогдох баримт бичиг дугнэлт
- Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болохыг нотлох баримт
- Сүүлийн 1 жилийн санхүүгийн тайлан, орлого нотлох баримтууд
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, лавлагаа
- Сангаас шаардах нэмэлт материалууд
- Үйлчилгээний хураамж төлсөн баримт
- НӨАТ төлөгч болохыг нотлох баримт /Ажлын байрыг дэмжих зээлийн батлан даалтад нэмж шаардана./

### Батлан даалт гаргахад хориглох заалтууд

- Зээл авах хүсэлт гаргахаас өмнө 6 сарын хугацаанд зээлдэгч, түүний холбогдох этгээд нь чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл, баталгаа, батлан даалт, түүнтэй адилтгах аккредитивын өрийн үлдэгдэлтэй байсан;
- Өмнө авсан хөнгөлттэй төслийн зээл, батлан даалтыг зориулалт бусаар зарцуулсан нь нотлогдсон;
- Сангаас шаардсан баримт, материал, нэмэлт мэдээллийг өгөхөөс татгалзсан;
- Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
- Тухайн зээл нь өмнөх зээлийг хаах зориулалттай /тухайн зээлийн 75-иас доош хувийг шилжүүлэхэд хамаарахгүй/;
- Тухайн зээл нь хэсэгчлэн олголт хийх нөхцөлтэй;
- Барьцаалах боломжтой хөрөнгийг сүүлийн 6 сарын хугацаанл бусдад үнэ төлбөргүй хэлбэрээр шилжүүлсэн худалдсан;
- Шугамын зээл, Хэрэглээний зээл;
- Сантай ижил төрлийн гуравдагч этгээдээр баталгаа, батлан даалт гаргуулсан бол;
- Барьцаа хөрөнгө хүрэлцээтэй;
- Зээлийн батлан даалтын хорооноос батлан даалт гаргах болон батлан даалттай холбоотой бусад хүсэлтийг 2 удаа татгалзан шийдвэрлэснийг сүүлийн шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор дахин ирүүлсэн;
- Компаний хувьцаа эзэмшигч нь сүүлийн 6 сарын хугацаанд хувьцаа эзэмшигчээс хасагдсан;


***УЛААНБААТАР***
***Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Гэрэгэ тауэр, 6-р давхар***

***Зээлийн батлан даалтын сан***
***7700-2035***

***info@cgf.mn***
***www.lgf.mn***